

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

“ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТӨВ” ТӨААТҮГ-ЫН 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: САГ-2019/67/СТА-ТӨААТҮГ**

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	2
2	Аудитын тайлан .....	3
2.1.	Оршил .....	3
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	3
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	4
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.8.1	Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл.....	7
2.8.2	Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл .....	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	10
3	Менежментийн захидал .....	11
3.1	Авлагатай холбоотой асуудал .....	11
3.1.1	Илрүүлэлт: .....	11
3.1.2	Эрсдэл:.....	11
3.1.3	Өгсөн зөвлөмж:.....	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	13
4.4.1	Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан .....	13
4.2	Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан .....	15
4.3	Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан .....	17
4.4	Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан .....	18
5.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	20

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨААТҮГ	Төрийн Өмчит Аж Ахуйн Тооцоот Үйлдвэрийн газар
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани



"ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТӨВ"  
ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ Н.ГАНБОЛД  
ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.03.20 № 06/539  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Геологийн судалгааны төв" ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол "Геологийн судалгааны төв" ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "Геологийн судалгааны төв" ТӨААТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Аудитын гол асуудал


Аудитаар "Геологийн судалгааны төв" ТӨААТҮГ-ын 2018 оны худалдан авах ажиллагааг шалгаж үзэхэд "Голлох ашигт малтмалын хэтийн төлөвийн судалгаа" төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нэр бүхий 4 компанитай нийт 1,003.8 сая төгрөгийн шууд гэрээ байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ", 8 дугаар зүйлийн 8.4 "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", 33 дугаар зүйлийн 33.2.1 "техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш эдгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх", 41 дүгээр зүйлийн 41.2.1 "Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно", 46 дугаар зүйлийн 46.1.4 "худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах" зэрэг заалтуудыг тус тус зөрчсөн байна.

## Үүрэг, хариуцлага

"Геологийн судалгааны төв" ТӨААТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2 Аудитын тайлан

---

### 2.1. Оршил

"Геологийн судалгааны төв" ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг Геологийн судалгааны төв ТӨААТҮГ-ын захирал Н.Ганболд Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн авлага барагдуулахтай холбоотой зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Геологийн судалгааны төв" ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

"Геологийн судалгааны төв" ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

"Геологийн судалгааны төв" ТӨААТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 10 дугаар сарын 03-наас 2019 оны 03 дугаар сарын 02-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 04-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, "Шонхор үнэлгээ Аудит" ХХК-ийн аудитор Д.Уранчимэг хариуцаж хэрэгжүүлэв.



"Геологийн судалгааны төв" ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газар-т 2019 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 37 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

"Геологийн судалгааны төв" ТӨААТҮГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Геологийн судалгааны төв” ТӨААТҮГ нь Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд региональ геологийн болон бүх төрлийн ашигт малтмалын иж бүрэн судалгаа хийх, төрд мэргэшсэн геологич бэлтгэн ажиллана гэж чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2014 оны 248 дугаар тогтоолоор "Геологийн судалгааны төв" ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлжээ. Үүнд:

- Геологийн иж бүрэн судалгаа болох геофизик, геохими, ерөмдлөг, геологийн региональ болон тандан судалгааны ажлыг мөрдөж буй арга аргачлалын дагуу гүйцэтгэх;

- Эрэл хайгуулын ажлыг мөрдөж буй аргачлалын дагуу гүйцэтгэх;
- Лабораторийн зарим шинжилгээг стандарт, зааврын дагуу гүйцэтгэх;
- Судалгааны явцад илэрсэн ашигт малтмалын шинэ илэрц, геологийн шалгуур, палеонтологийн олдворын талаар холбогдох газарт мэдээлж, цаашдын судалгааны чиглэлийн талаар зөвлөмж өгөх, харилцан мэдээлэл солилцох;
- Геологийн судалгааны ажлын анхдагч материалыг боловсруулан үр дүнгийн тайлан, зураг зэрэг мэдээллийг хугацаанд нь иж бүрнээр бэлтгэн, эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, геологийн мэдээллийн төвд тушаах;
- Геологийн судалгааны ажилд нэвтэрч байгаа дэлхийн улс орнуудын дэвшилтэт арга, аргачлал, техник технологийг нэвтрүүлэх, сургалт, эрдэм, шинжилгээний байгууллагатай нягт хамтран ажиллах;
- Хуулиар хориглоогүй аж ахуйн бусад үйл ажиллагааг эрх бүхий байгууллагын зөвшөөрснөөр эрхлэх;

"Геологийн судалгааны төв" ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

"Геологийн судалгааны төв" ТӨААТҮГ-ын удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Ашигт малтмалын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэл ороогүй байна.



## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

"Геологийн судалгааны төв" ТӨААТҮГ-ын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

"Геологийн судалгааны төв" ТӨААТҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

"Геологийн судалгааны төв" ТӨААТҮГ-ын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Пирамид-4.1” програм хангамж ашигладаг бөгөөд 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн “Diamond” програм руу шилжихээр ажиллаж байна.

"Геологийн судалгааны төв" ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад "Геологийн судалгааны төв" ТӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Санхүүгийн үр дүнгийн тайлангийн *нийт орлогыг* сонгож түүний 1 хувиар тооцлоо.

*Нийт орлого* -г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь "Геологийн судалгааны төв" ТӨААТҮГ нь Уул уурхай хүнд үйлдвэрийн яамнаас зарласан тендерт шалгарснаар 2018 онд 5,971.2 сая төгрөгийн орлого орж ирснийг харгалзан сонгосон.

"Геологийн судалгааны төв" ТӨААТҮГ-ын 2018 оны *нийт орлого* 5,988.6 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 59.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь төлөвлөлтийн шатанд эрсдэл дунд байсантай холбоотой холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 9 чиглэлээр аудитын 16 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 3 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

### 2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, "Геологийн судалгааны төв" ТӨААТҮГ-ын удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- Нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд 9.9 сая төгрөгний орлого дутуу тайлагнасан.
- Шатах тосох материалын тайлан хийгээгүй, 1.0 сая төгрөгний сэлбэг няравын тайланд орлогод аваагүй
- Анхан шатны баримтгүй 1.1 сая төгрөг, томилолтын тооцоо хийгээгүй 5.9 сая төгрөгийг тус тус зарлагадсан зэрэг асуудлыг залруулсан.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

## 2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй  
асуудлыг ангилсан байдал

(мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	6,239.7	
2	Албан шаардлага өгсөн	1	1,003,953.0	
	Дүн	2	1,010,192.7	

### 2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Худалдан авах ажиллагаатай холбоотой шууд гэрээ байгуулсан дараах асуудлууд гарсан байна.

1. "Голлох ашигт малтмалын хэтийн төлөвийн судалгаа" төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд өөрийн байгууллагын гэрээгээр хүлээсэн үүргийг гуравдагч этгээдэд гэрээгээр шилжүүлсэн, шилжүүлэхдээ худалдан авах ажиллагааны холбогдох хуулийг хэрэгжүүлэлгүй дараах аж ахуй нэгж байгууллагуудтай шууд гэрээ байгуулсан байна. Үүнд: Өрөм түрээслэхээр Топ даймонд дриллинг ХХК, Нью повер дриллинг ХХК, Мянганы хас ХХК-иудтай 1 өдрийн түрээсийн төлбөр 2.6 сая төгрөг байхаар нийт 967.2 сая төгрөг, дээж шинжлүүлэхээр “Ар си инспекшн азиа ассайрс” ХХК-д 36.6 сая төгрөгийг тус тус шилжүүлжээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”, 8 дугаар зүйлийн 8.4 “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”, 33 дугаар зүйлийн 33.2.1 “техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх”, 41 дүгээр зүйлийн 41.2.1 “Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно”, 46 дугаар зүйлийн 46.1.4 “худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах” зэрэг заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

#### 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Улсын төсвийн хөрөнгөөр 2017-2020 онд Бүс нутгийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих "Голлох ашигт малтмалын хэтийн төлөвийн судалгаа" төслийн хүрээнд байгуулсан гэрээ хэлэлцээрүүд түүний хэрэгжилт холбогдох хуулийн дагуу хэрэгжиж байгаа эсэх.

#### 2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн өмчит хуулийн этгээдийн батлагдсан төлөвлөгөө, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

2018 онд "Геологийн судалгааны төв" ТӨААТҮГ-ын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 5,991.0 сая төгрөгний нийт зардал батлагдсанаас 5,473.6 сая төгрөгийг зарцуулж 517.5 сая төгрөгний хэмнэлт гаргасан байна.

Энэ нь бусдаар гүйцэтгүүлэхээр төлөвлөсөн ажлыг өөрсдийн хүчээр гүйцэтгэн хэмнэлт гаргасан байна.

#### 2.11. Шилэн дансны мэдээлэл

"Геологийн судалгааны төв" ТӨААТҮГ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

"Геологийн судалгааны төв" ТӨААТҮГ нь 18 мэдээллийг шилэн дансанд оруулахаас 11 мэдээллийг оруулж 7 мэдээллийг огт оруулаагүй, Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт зэрэг тайланг жилийн эцсийн байдлаар шилэн данс руу оруулахдаа хугацаа хоцорч байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

#### 2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 1 асуудал буюу авлага барагдуулах ажил хийгдээгүй байгаа тул 50%- хувьтай байна.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### 2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид "Геологийн судалгааны төв" ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Геологийн судалгааны төв" ТӨААТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь "Геологийн судалгааны төв" ТӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Авлагатай холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Өмнөх аудитын зөвлөмжөөр өгөгдсөн нэр бүхий 7 иргэн, аж ахуйн нэгжээс авах 6.2 сая төгрөгний авлагыг барагдуулаагүй, авсан арга хэмжээ нь шаардлага хангаагүй.

##### **3.1.2 Эрсдэл:**

Энэ нь Төсвийн тухай хууль 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэнтэй нийцэхгүй байна.

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 6 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



#### 4.Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	12/31/2017	12/31/2018
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	495,209,741.19	897,068,064.01
1.1.2	Дансны авлага	20,612,564.70	6,239,725.20
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	15,962,004.35	16,199,088.18
1.1.4	Бусад авлага	213,290,606.00	140,491,556.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	29,697,307.65	9,770,521.98
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>774,772,223.89</b>	<b>1,069,768,955.37</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	264,700,442.77	364,151,837.76
1.2.2	Биет бус хөрөнгө		174,783,800.00
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>264,700,442.77</b>	<b>538,935,637.76</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,039,472,666.66</b>	<b>1,608,704,593.13</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	27,136,880.00	9,600,000.00
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	17,848,438.01	40,740,995.56

“Геологийн судалгааны төв” ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

2.1.1.4	НДШ–ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	139,413,680.00	148,003,520.00
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>184,398,998.01</b>	<b>198,344,515.56</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>184,398,998.01</b>	<b>198,344,515.56</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	979,226,789.06	979,226,789.06
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	17,815,186.59	154,598,986.59
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	61,406,293.85	39,589,627.18
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-203,374,600.85	236,944,674.74
2.3.10			
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>855,073,668.65</b>	<b>1,410,360,077.57</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,039,472,666.66</b>	<b>1,608,704,593.13</b>

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	12/31/2017	12/31/2018
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>2,626,890,050.17</b>	<b>5,988,585,073.39</b>
2	Борлуулалтын өртөг	1,982,910,806.72	5,033,124,981.47
<b>3</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>643,979,243.45</b>	<b>955,460,094.92</b>
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого	3,317,767.30	16,047,572.12
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	-198,464,978.17	-368,869,769.38
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	-22,098,716.35	-79,378,482.81
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-99,375.52	-8,250,247.50
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-16,896,630.70	
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг ( алдагдал)		
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>409,737,310.01</b>	<b>515,009,167.35</b>
19	Орлогын татварын зардал	22,785,257.10	59,404,805.76
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>386,952,052.91</b>	<b>455,604,361.59</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>386,952,052.91</b>	<b>455,604,361.59</b>

<b>23</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>386,952,052.91</b>	<b>455,604,361.59</b>
<b>25</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуриртлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	<b>979,226,789.06</b>	<b>17,815,186.59</b>		<b>-590,326,653.76</b>	<b>406,715,321.89</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
3	Залруулсан үлдэгдэл	<b>979,226,789.06</b>	<b>17,815,186.59</b>		<b>-590,326,653.76</b>	<b>406,715,321.89</b>
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)				386,952,052.91	<b>386,952,052.91</b>
5	Бусад дэлгэрэнгүй орлого					
6	Өмчид гарсан өөрчлөлт			61,406,293.85		<b>61,406,293.85</b>
7	Зарласан ногдол ашиг					
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
9	2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	<b>979,226,789.06</b>	<b>17,815,186.59</b>	<b>61,406,293.85</b>	<b>-203,374,600.85</b>	<b>855,073,668.65</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				23,410,114.00	<b>23,410,114.00</b>

“Геологийн судалгааны төв” ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

11	Залруулсан үлдэгдэл	<b>979,226,789.06</b>	<b>17,815,186.59</b>	<b>61,406,293.85</b>	<b>-179,964,486.85</b>	<b>878,483,782.65</b>
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				455,604,361.59	<b>455,604,361.59</b>
13	Бусад дэлгэрэнгүй орлого					
14	Өмчид гарсан өөрчлөлт			-21,816,666.67		<b>-21,816,666.67</b>
15	Зарласан ногдол ашиг				-38,695,200.00	<b>-38,695,200.00</b>
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		136,783,800.00			<b>136,783,800.00</b>
17	2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	<b>979,226,789.06</b>	<b>154,598,986.59</b>	<b>39,589,627.18</b>	<b>236,944,674.74</b>	<b>1,410,360,077.57</b>



4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	12/31/2017	12/31/2018
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>2,885,330,281.20</b>	<b>6,623,533,946.50</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,784,321,197.20	6,508,922,198.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	10,895,462.00	10,166,625.00
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	90,113,622.00	104,445,123.50
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>2,389,796,152.15</b>	<b>5,970,626,288.30</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	934,432,696.00	1,454,075,259.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	214,651,222.00	332,894,898.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	156,247,235.65	259,551,629.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	37,909,524.94	34,930,212.07
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	122,687,887.72	228,716,100.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	5,551,232.87	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	335,543,888.69	573,747,787.20
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	1,810,080.00	2,227,770.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	580,962,384.28	3,084,482,633.03
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>495,534,129.05</b>	<b>652,907,658.20</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>4,647,767.30</b>	<b>16,747,572.12</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	1,330,000.00	700,000.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	3,317,767.30	16,047,572.12
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8			
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>92,348,908.00</b>	<b>229,441,300.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	92,348,908.00	191,441,300.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		38,000,000.00

“Геологийн судалгааны төв” ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.2.6			
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-87,701,140.70</b>	<b>-212,693,727.88</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>400,000,000.00</b>	<b>0,00</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	400,000,000.00	
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4			
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>400,099,375.52</b>	<b>38,695,200.00</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	400,000,000.00	
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		38,695,200.00
3.2.5			
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>0,00</b>	<b>-38,695,200.00</b>
<b>4</b>	<b>Валютын ханшийн зөрүү</b>	<b>-99,375.52</b>	<b>339,592.50</b>
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>407,733,612.83</b>	<b>401,858,322.82</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>87,476,128.36</b>	<b>495,209,741.19</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>495,209,741.19</b>	<b>897,068,064.01</b>

“Геологийн судалгааны төв” ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

4.5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018.12.31	Аудитын нэр:	2018 оны санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2019/67/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	“Геологийн судалгааны төв” ТӨААТҮГ			сая төгрөгөөр	

№	Аудитын зорилт, чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5			9	10
1	Худалдан авах ажиллагаа	1	1. "Голлох ашигт малтмалын хэтийн төлөвийн судалгаа" төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд өөрийн байгууллагын гэрээгээр хүлээсэн үүргийг гуравдагч этгээдэд гэрээгээр шилжүүлсэн, шилжүүлэхдээ худалдан авах ажиллагааны холбогдох хуулийг хэрэгжүүлэлгүй дараах аж ахуй нэгж байгууллагуудтай шууд гэрээ байгуулсан байна. Үүнд: Өрөм түрээслэхээр Топ даймонд дриллинг ХХК, Нью повер дриллинг ХХК, Мянганы хас ХХК-иудтай 1 өдрийн түрээсийн төлбөр 2,600.0 мянган төгрөг байхаар нийт 967,200.0 мянган төгрөг, дээж шинжлүүлэхээр “Ар си инспекшн азиа ассайрс” ХХК-д 36,630.0 мянган төгрөгийг тус тус шилжүүлсэн.	1,003.8	Албан шаардлага өгсөн			Дарга, Нягтлан бодогч	Н.Ганболд, Т.Батбилэг
2	Авлага	1	Өмнөх аудитын зөвлөмжөөр өгөгдсөн нэр бүхий 7 иргэн, аж ахуй нэгжээс авах 6.2 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй.	6.2	Зөвлөмж өгсөн			Дарга, Нягтлан бодогч	Н.Ганболд, Т.Батбилэг
<b>НИЙТ ДҮН</b>				<b>1,010.0</b>					

